

## Тойм ба үндэслэл

<p><b>Үзүүлэлт</b></p>	<p><b>1. СББӨ-ийн цаашдын практик болон өвлүүлэн уламжлуулах үйл явцад эрх бүхий этгээд болон байгууллагууд хэрхэн дэмжлэг үзүүлдэг тухай.</b></p>	
<p><b>Үнэлгээний хүчин зүйлүүд</b></p>	<p>Энэ үзүүлэлтийг оролцогч талуудаар хянуулж, тайлагнасан үндэсний түвшний таван хүчин зүйл дээр үндэслэн үнэлдэг:</p>	
	<p>Нэг эсвэл хэд хэдэн СББӨ-ийг хамгаалах эрх зүйн байгууллагууд томилогдсон буюу байгуулагдсан.</p>	<p>Зүйл: 13(b) OD 154(a)</p>
	<p>1.2 Бүртгэгдсэн эсэхээс үл хамааран СББӨ-ийн тодорхой элементүүдийг хамгаалах эрх бүхий байгууллагууд байх.</p>	<p>Зүйл: 13(b) OD 158(a), OD 162(d)</p>
	<p>1.3 СББӨ-ийн хамгаалалт, менежментэд ялангуяа хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн өргөн, хүртээмжтэй оролцоог зөвлөх байгууллага эсвэл бусад зохицуулалтын механизмаар дамжуулан дэмжих.</p>	<p>OD 80</p>
	<p>1.4 СББӨ-ийн баримт бичгийн талаарх байгууллага, эсвэл санаачилгыг дэмжих бөгөөд эдгээр материалуудыг СББӨ-ийн цаашдын практик болон өвлүүлэн уламжлуулах үйл явцад ашиглагдана.</p>	<p>Зүйл: 13(d)(iii)</p>
	<p>1.5 Соёлын төвүүд, мэргэшсэн төвүүд, судалгааны байгууллагууд, музей, архив, номын сангууд зэрэг нь СББӨ-ийн хамгаалалт, менежментэд хувь нэмэр оруулах.</p>	<p>OD 79, OD 109</p>
<p><b>ТХЗ болон бусад үзүүлэлтийн холбоо хамаарал</b></p>	<p><b>Тогтвортой хөгжлийн зорилго:</b> ТХЗ 11.4 “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах хүчин чармайлтыг бэхжүүлэн бататгах”. Албан ёсны байгууллагуудыг эсвэл хамгаалалтад олон нийтийн өргөнөөр оролцох оролцоог зохицуулах механизмыг урамшуулах замаар, Үнэлгээний хүчин зүйл 1.3 нь ТХЗ-ын 16.6 “Үр дүнтэй, хариуцлагатай, ил тод байгууллагуудыг бүх түвшинд хөгжүүлэх” болон зорилт 16.7 “Хариуцлагатай, хүртээмжтэй, оролцоотой, төлөөллийн шийдвэр гаргалтыг бүх түвшинд хангах.” -тай тус тус зохицон нөхцөлдөж байна.</p> <p><b>Бусад үзүүлэлтийн холбоо хамаарал:</b> Энэхүү үзүүлэлт нь институтийн чадавхад төвлөрдөг бол Үзүүлэлт-2 нь хүний чадавхыг илүү голлон авч үздэг. Энд хамрагдсан байгууллага, институтууд нь ихэвчлэн төрийн байгууллага эсвэл засгийн газрын дэмжлэгтэйгээр байгуулагдсан байдаг бол, ТББ болон олон нийтийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагуудын нэмэлт үйл ажиллагааг 21-р үзүүлэлтэд тусгасан болно. Судалгаа, баримт бичгийн үйл ажиллагаа, үр дүнг 9 болон 10-р үзүүлэлтүүдэд авч үзнэ. Судалгааны байгууллагууд болон мэргэшсэн төвүүдийн оролцоог Үзүүлэлт-22-т харин байгууллага болон төвүүдийн олон улсын сүлжээ холбоог Үзүүлэлт-25-т тус тус тусгасан болно.</p>	

<p><b>Үйл ажиллагааны үндэслэл</b></p>	<p>13(b) зүйл нь оролцогч улсын 1 эсвэл хэд хэдэн СББӨ-ийг хамгаалах чадамжтай эрх бүхий байгууллагыг байгуулах болон томилох тухай үүрэг хариуцлагыг тодорхойлон өгсөн. Конвенцод институтийн дэд бүтцийг үр дүнтэй хамгаалах урьдчилсан нөхцөл гэж үздэг бөгөөд олон оронд эдгээр байгууллагууд конвенцыг үндэсний түвшинд хэрэгжүүлэх тодорхой үүрэг хариуцлага хүлээдэг. Энэхүү конвенц нь олон нийт, бүлэг, хувь хүмүүсийг гол төв болгон, бусад оролцогчдын оролцоог урьдчилан тооцдог тул улс орнууд ийм оролцоог зохицуулах нэмэлт байгууллага, механизмыг бий болгох нь зүйтэй гэж үздэг. Хамгаалах байгууллагууд эсвэл институциуд-д соёлын төвүүд, мэргэжлийн төвүүд, музей, архив, номын сан болон бусад судалгааны байгууллагуудыг багтаадаг бөгөөд эдгээр байгууллагууд нь СББӨ-ийг баримтжуулах үүрэгтэй юм (13(d) (iii) зүйл нь СББӨ-ийг хамгаалах, менежментэд томоохон үүргийг мөн гүйцэтгэнэ).</p>
<p><b>Түлхүүр үг</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрх бүхий байгууллага</li> <li>• СББӨ-ийн элемент</li> <li>• Бичигдсэн ( тусгагдсан эсэхээс үл хамааран)</li> <li>• Хамааруулсан/Хамаатгасан</li> <li>• Оролцоо эсвэл оролцсон байдал</li> <li>• Олон нийт, бүлэг, хувь хүн</li> <li>• Зөвлөх байгууллага эсвэл зохицуулалтын механизм</li> <li>• Мэргэшсэн төвүүд</li> <li>• Судалгааны байгууллагууд</li> </ul>

### **Хяналт-шинжилгээ хийх, үе үе тайлагнах тухай тусгай заавар**

<p><b>Хяналтын ашиг тус</b></p>	<p>Энэ үзүүлэлтэд хяналт тавих нь оролцогч улсад СББӨ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын төлөвлөлт зургийг гаргаж, байгууллагын сул талыг тодорхойлж шийдвэрлэхэд тусална. Энэ нь мөн СББӨ-ийг хамгаалах эрх бүхий байгууллагууд болон бусад оролцогчдын хамгаалах хүчин чармайлтыг үр дүнтэй дайчилж байгаа эсэхийг үнэлэхэд ач холбогдолтой. Дэлхийн түвшинд, хяналт нь СББӨ-ийг хамгаалах байгууллагын дэд бүтцийн ерөнхий тоймыг өгч, үр дүнтэй хэмээн батлагдсан зохицуулалтын механизмуудын жишээг санал болгоно.</p>
<p><b>Мэдээллийн эх сурвалж</b></p>	<p>Ихэнх тохиолдолд хяналт ба тайлагнахыг хариуцах алба нь үндэсний түвшинд СББӨ-ийг хамгаалах эрх бүхий байгууллага томилогддог тул энэ нь анхан шатны байгууллага, институт болон механизмын мэдээллийг авах боломжтой. Төрийн бусад байгууллагууд болон үндэсний байгууллагууд нь байнгын хамтран ажиллагсад, түншүүд түүний дотор соёлоос бусад салбарынхантай илүү давтамжтай байх магадлалтай байдаг. Мөн мужийн болон орон нутгийн байгууллагыг анхаарч үзэх нь маш чухал сэдэв болох бөгөөд, гэхдээ энэ нь байнгын холбоо, сүлжээ шаардагдана. Ялангуяа Үнэлгээний хүчин зүйл-1.2 болон СББӨ-ийн тодорхой элементүүдийг хамгаалах эрх бүхий байгууллагуудын хувьд, оролцогч улс нь орон нутгийн түвшинд юу болж байгааг хянахын тулд тогтмол судалгаа явуулах шаардлага үүснэ. Хэрвээ зөвлөлийн байгууллага эсвэл зохицуулалтын механизм зэрэг /жишээ нь олон түвшний хяналт/ байвал илүү үр дүнтэй байх болно.</p> <p><b>Эх сурвалж</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Албан ёсны хэвлэл/сэтгүүл, хууль ба эрх зүйн зохицуулалтын эмхэтгэл</li> </ul>

	<ul style="list-style-type: none"><li>● Засгийн газрын соёлын болон өвийн байгууллагын жилийн төсөв, ажлын төлөвлөгөө болон тайлан.</li><li>● Үндэсний түвшний зөвлөлийн байгууллагын жилийн тайлан тэмдэглэл</li><li>● Үндэсний жагсаалт эсвэл ЮНЕСКО-гийн аль нэг жагсаалтад бүртгэгдсэн элементүүдийн талаар улсдаа тайлагнасан үе үеийн тайлан</li><li>● Соёлын газар болон өвийн байгууллагын вебсайт, лавлах</li></ul>
--	--